



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас/факс: (976) 7044 2584
Вэбсайт: bayankhongor@audit.gov.mn

2022. 02. 24 № 1/169

танай _____ -ны № _____ -г

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Г.СҮХБААТАР ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд танай байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд баталгаажуулах аудит хийж, аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж байна.

Аудитаар өгсөн албан шаардлагыг тогтоосон хугацаанд барагдуулж, биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ний дотор ирүүлнэ үү.

Хавсралт. 18.....хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/56/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Д.Цэцэгмаа Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

1. Аудитын гэрчилгээ /эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1. Залруулсан алдаа	18
4.2. Албан шаардлага	18
4.3. Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/80

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Г.СҮХБААТАР ТАНАА

танай _____-ны № _____-г
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

• 035020416

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>65,542,206.90</u>	<u>376,240,152.76</u>
33	АВЛАГА	350,000.00	310,758,782.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	350,000.00	782.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	310,718,000.00
335	Бусад авлага	00.00	40,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	40,000.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	1,100,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	00.00	1,100,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	00.00	1,100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	65,192,206.90	64,381,370.76
351	Түүхий эд материал	36,215,656.84	38,382,809.00
35110	Тусгай зориулалттай материал	27,034,978.33	26,649,119.00
35130	Эм боох материал	9,180,678.51	11,733,690.00
354	Хангамжийн материал	28,976,550.06	25,998,561.76
35410	Бичиг хэргийн материал	1,631,500.00	1,600,100.00
35420	Аж ахуйн материал	24,248,900.00	23,674,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,367,300.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	00.06	352,161.76
35450	Барилгын засварын материал	1,085,000.00	350,000.00
35460	Хүнсний материал	643,850.00	22,050.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>458,741,886.06</u>	<u>514,266,215.43</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	458,741,886.06	514,266,215.43
392	Биет хөрөнгө	440,401,886.06	495,926,215.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	414,301,558.00	414,301,558.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,958,081.92	-27,687,122.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,640,000.00	43,640,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,525,555.61	-31,352,222.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,926,859.18	184,021,462.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,021,880.86	-104,587,541.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,180,105.00	26,995,805.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,190,451.18	-14,019,923.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,633,000.00	13,633,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,653,666.55	-9,388,799.83
39217	Ном	70,000.00	370,000.00
393	Биет бус хөрөнгө	18,340,000.00	18,340,000.00
39301	Програм хангамж	650,000.00	650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-650,000.00	-650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,340,000.00	18,340,000.00

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>524,284,092.96</u>	<u>890,506,368.19</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,963,648.90</u>	<u>92,964,458.01</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,963,648.90	92,964,458.01
413	Өглөг	1,963,648.90	92,964,458.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	5,500,008.55
4136	Бусад өглөг	1,963,648.90	87,464,449.46
41361	Байгууллагад төлөх өглөг	1,963,648.90	87,464,449.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>522,320,444.06</u>	<u>797,541,910.18</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	522,320,444.06	797,541,910.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	580,017,310.00	580,017,310.00
51101	Өмч: - төрийн	580,017,310.00	580,017,310.00
512	Хуримтлагдсан үр дүн	-126,615,475.49	148,605,990.63
51210	Өмнөх үеийн үр дүн	-126,615,475.49	-126,615,475.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	275,221,466.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	68,918,609.55	68,918,609.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>524,284,092.96</u>	<u>890,506,368.19</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	418,620,127.23	983,362,469.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,291,777.23	90,710,567.02
120	Нийтлэг татварын бус орлого	21,291,777.23	90,710,567.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,291,777.23	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,291,777.23	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		62,977,103.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		27,733,463.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	397,328,350.00	892,651,902.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354,536,100.00	404,607,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,345,400.00	443,504,562.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,345,400.00	81,433,012.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,696,550.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		359,375,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,137,800.00	28,883,240.00

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,137,800.00	28,883,240.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,309,050.00	15,656,600.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,309,050.00	15,656,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	411,298,582.12	708,141,002.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411,298,582.12	708,141,002.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411,270,738.12	646,722,535.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,723,056.09	321,334,316.00
210101	Үндсэн цалин	222,538,808.09	321,080,996.00
210102	Нэмэгдэл	39,733,931.00	00.00
210104	Урамшуулал	9,450,317.00	253,320.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,386,265.00	39,657,282.84
210201	Тэтгэврийн даатгал	24,316,723.00	27,658,916.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,827,274.00	3,138,518.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,261,821.00	2,510,813.00
210204	Ажилгүйдлийн даатгал	543,677.00	574,554.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,436,770.00	5,774,481.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,897,972.94	27,510,387.65
210301	Гэрэл, цахилгаан	2,775,573.00	3,988,122.65
210302	Түлш, халаалт	17,087,399.94	23,261,040.00
210303	Цэвэр, бохир ус	35,000.00	261,225.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,012,391.00	49,881,485.54
210401	Бичиг хэрэг	1,190,600.00	1,869,600.00
210402	Тээвэр, шатахуун	23,515,841.00	22,317,962.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,297,900.00	1,406,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,000.00	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,963,050.00	6,349,700.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	17,617,423.24
2105	Нормативт зардал	20,108,451.30	104,169,562.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,117,261.30	52,900,987.56
210502	Хоол, хүнс	5,991,190.00	51,268,575.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	859,100.00	5,176,900.00
210604	Урсгал засвар	859,100.00	5,176,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,070,000.00	976,000.00
210702	Дотоод албан томилолт	1,070,000.00	976,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,659,088.00	20,783,334.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,259,088.00	20,333,334.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,554,413.70	77,233,266.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	803,000.00	54,547,292.50

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,751,413.70	22,685,974.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,844.00	61,418,467.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	61,099,678.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	61,099,678.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,962.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,562.00	00.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	400.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,882.00	318,789.62
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,882.00	318,789.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>7,321,545.11</u>	<u>275,221,466.12</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>7,321,545.11</u>	<u>275,221,466.12</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>397,328,350.00</u>	<u>581,933,902.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>397,328,350.00</u>	<u>581,933,902.00</u>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354,536,100.00	404,607,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,345,400.00	132,786,562.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,345,400.00	81,433,012.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,696,550.00
131107	Эрүүл мэндийн сангийн нэмэлт оролого		48,657,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,137,800.00	28,883,240.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,137,800.00	28,883,240.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,309,050.00	15,656,600.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,309,050.00	15,656,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>394,228,350.00</u>	<u>566,700,702.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>394,228,350.00</u>	<u>566,700,702.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>394,200,506.00</u>	<u>505,282,234.38</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,787,125.00	293,427,999.38
210101	Үндсэн цалин	188,431,572.93	174,179,984.58
210102	Нэмэгдэл	62,893,549.52	80,489,917.70

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,312,999.05
210104	Урамшуулал	14,462,002.55	33,445,098.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,712,000.00	40,494,100.00
210201	Тэтгэврийн даатгал	25,741,700.00	28,495,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,742,100.00	2,999,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,194,500.00	2,399,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	548,600.00	599,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,485,100.00	5,999,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,131,338.00	26,984,040.00
210301	Гэрэл, цахилгаан	2,775,573.00	3,323,000.00
210302	Түлш, халаалт	17,182,865.00	23,261,040.00
210303	Цэвэр, бохир ус	172,900.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,827,141.00	32,486,301.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	2,196,800.00
210402	Тээвэр, шатахуун	21,055,741.00	21,132,401.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,682,900.00	1,547,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,938,500.00	1,660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950,000.00	5,950,000.00
2105	Нормативт зардал	18,059,490.00	37,683,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,041,900.00	27,704,800.00
210502	Хоол, хүнс	6,298,790.00	7,468,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,718,800.00	2,510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,856,900.00	3,059,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	857,000.00	00.00
210604	Урсгал засвар	999,900.00	3,059,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,070,000.00	976,000.00
210702	Дотоод албан томилолт	1,070,000.00	976,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,026,112.00	66,269,384.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,626,112.00	65,819,384.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,730,400.00	3,902,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,730,400.00	3,902,010.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,844.00	61,418,467.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	61,099,678.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	61,099,678.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,962.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,562.00	00.00
213404	Хөрөнгийн	400.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,882.00	318,789.62
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,882.00	318,789.62

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,100,000.00	9,365,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,100,000.00	15,233,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,100,000.00	15,233,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,100,000.00	15,233,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,100,000.00	15,233,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,100,000.00	-15,233,200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	561.677.310.00	59.739.971.00	-70.918.791.85	00.00	550.498.489.15
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	561.677.310.00	59.739.971.00	-70.918.791.85	00.00	550.498.489.15
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-40.805.775.91	00.00	-40.805.775.91
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	580.017.310.00	68.918.609.55	-126.615.475.49	00.00	522.320.444.06
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	580.017.310.00	68.918.609.55	-126.615.475.49	00.00	522.320.444.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	580.017.310.00	68.918.609.55	-126.615.475.49	00.00	522.320.444.06
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	275.221.466.12	00.00	275.221.466.12
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	580.017.310.00	68.918.609.55	148.605.990.63	00.00	797.541.910.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	455.678.100.00	448.828.550.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	455.678.100.00	448.828.550.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455.678.100.00	448.828.550.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299.956.600.00	293.427.999.38
210101	Үндсэн цалин	185.161.000.00	174.179.984.58
210102	Нэмэгдэл	80.508.400.00	80.489.917.70

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5.313.000.00	5.312.999.05
210104	Урамшуулал	28.974.200.00	33.445.098.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40.494.100.00	40.494.100.00
210201	Тэтгэврийн даатгал	28.495.800.00	28.495.800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2.999.600.00	2.999.600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.399.700.00	2.399.700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	599.900.00	599.900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5.999.100.00	5.999.100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26.985.400.00	26.984.040.00
210301	Гэрэл, цахилгаан	3.323.000.00	3.323.000.00
210302	Түлш, халаалт	23.262.400.00	23.261.040.00
210303	Цэвэр, бохир ус	400.000.00	400.000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33.126.400.00	33.126.301.00
210401	Бичиг хэрэг	2.196.800.00	2.196.800.00
210402	Тээвэр, шатахуун	21.132.500.00	21.132.401.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.547.100.00	1.547.100.00
210404	Ном, хэвлэл	300.000.00	300.000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2.000.000.00	2.000.000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5.950.000.00	5.950.000.00
2105	Нормативт зардал	37.683.200.00	37.683.200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27.704.800.00	27.704.800.00
210502	Хоол, хүнс	7.468.400.00	7.468.400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2.510.000.00	2.510.000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9.400.000.00	9.284.900.00
210602	Тавилга	6.000.000.00	5.885.700.00
210604	Урсгал засвар	3.400.000.00	3.399.200.00
2107	Томилолт, зочны зардал	1.128.000.00	976.000.00
210702	Дотоод албан томилолт	1.128.000.00	976.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450.000.00	450.000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450.000.00	450.000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6454400.00	6402010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6.454.400.00	6.402.010.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	455.678.100.00	448.828.550.38
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	404.607.500.00	404.288.710.38
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	404.607.500.00	404.288.710.38
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28.885.400.00	28.883.240.00
132001	Орон нутгийн төсвөөс	28.885.400.00	28.883.240.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22.185.200.00	15.656.600.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22.185.200.00	15.656.600.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	26.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	08.00	09.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	28.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16.00	16.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	09.00	09.00
650010	Гэрээт ажилтан	04.00	03.00

2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,345,400.00	132,786,562.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,345,400.00	126,919,062.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,345,400.00	65,819,384.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,345,400.00	65,819,384.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,345,400.00	65,819,384.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	61,099,678.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		61,099,678.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		61,099,678.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		5,867,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр		5,867,500.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		5,867,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4345400.00	132786562.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4345400.00	132786562.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4345400.00	81,433,012.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,696,550.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		48,657,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Г.Сүхбаатар нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч О.Бямбасүрэн нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гурванбулаг сумын ЭМТ нь Хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх анхан шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар, хүртээмжтэй үзүүлэх чиг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 91 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 411,338.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,170.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,627.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 7,966.5 мянган төгрөг буюу 3,339.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь Ковид -19 цар тахалтай холбоотой нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМД-ын санхүүжилтийн 132,786.5 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан, ЭМДС-гийн дутуу санхүүжилтийн 310,718.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланг орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүссэнтэй холбоотой тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 890,506.4 мянган төгрөг болж өмнөх оноос 366,222.3 мянган төгрөгөөр буюу 41,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65.542.2	376.240.2	310.697.9
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	310.758.8	310.758.8
Урьдчилгаа	350.0	1.100.0	750.0
Бараа материал	65.192.2	64.381.4	(810.8)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	458.741.9	514.266.2	55.524.3
Үндсэн хөрөнгө	623.741.5	701.951.8	78.210.3
Хуримтлагдсан элэгдэл	(164.999.6)	(187.685.6)	(22.686.0)
Нийт хөрөнгө	524.284.1	890.506.4	366.222.3

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Өр төлбөр	1.963.6	92.964.5	91.000.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	522.320.4	797.541.9	275.221.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	524.284.1	890.506.4	366.222.3

Бараа материалын дансны үлдэгдэл 64,381.4 мянган төгрөг болж 810.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын үлдэгдэл 310,758.8 мянган төгрөг болсон нь ЭМД-ын сангаас авах Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрийн санхүүжилт хийгдээгүйтэй холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 92,964.5 мянган төгрөг болж өмнөх оноос 91,000.8 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын сангийн санхүүжилт хийгдээгүйгээс шалтгаалсан ба үүнээс “Цагаан уул фарм” ХХК-д 19,166.5 мянган төгрөгийн эмийн , “ЭМАД” ХХК-д 13,325.0 мянган төгрөгийн комбинзон болон бусад хамгаалах хэрэгслийн, ажиллагсадтай холбогдсон цалингийн 11,034.1 мянган төгрөгийн томоохон дүн бүхий өглөгтэй гарсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 701,951.8 мянган төгрөг болж 78,210.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8,367.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6,565.7 мянган төгрөгөөр тавилга эд хогшил, 300.0 мянган төгрөгөөр ном худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 24,207.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй, бусад компани иргэдээс 38,770.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар хүлээн авчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 797,541.9 мянган төгрөг болж 275,221.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн системийн байгууллагууд төсвийн төлөвлөлтийг хийхдээ цалингийн зардал, тогтмол зардлын төсвийг төлөвлөж, бусад суурь үзүүлэлтийг ЭМГ-т хүргүүлдэг ба системийн дээд байгууллага нь нэг иргэнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөдөг ба тайлант онд 455,678.1 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 455,678.1 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 404,607.5 мянга, орон нутгийн төсвөөс 28,885.4 мянга, ЭМДС-гаас 22,185.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 404,607.5 мянга, орон нутгийн төсвөөс 28,883.2 мянга, ЭМД-аас 15,656.6 мянга, нийт 449,147.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 448,828.5 мянган төгрөгийг зарцуулсан 318.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 2.1 мянган төгрөгөөр, ЭМД-аас авах санхүүжилтийг 6,528.6 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 448,828.5 мянган төгрөг буюу 98,5 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлын хэмнэлттэй холбоотой ба энэ нь батлагдсан орон тооны нормативаас 1 орон тоо дутуу ажилласнаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 132,786.5 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан байна. Нийт төвлөрсөн орлогын 48,657.0 мянган төгрөг нь Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрөөс орсон орлого байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа ЭМЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор ажилласан.

Ковид-19 цар тахлын хүрээнд Сумын онцгой комиссын шийдвэрийн дагуу тусгаарлан ажиглах байрыг Соёлын төвд 70 ортой, эмчийн байр, халдварт, эмийн сангийн арын өрөөнд 30 ортойгоор бэлтгэсэн. Мөн тусгаарлах эмнэлгийг 100 ортой бэлтгэн эм тариа, халдварын үеийн бэлэн байдлыг хангаж, нийт 392 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 35 ажлыг тусган хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд хэрэгжилт 95%-тай гэж тайлагнагдсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 708,141.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 296,831.0 мянган төгрөгөөр буюу 72,2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь нормативд зардал 84,061.1 мянга, цалин, НДШ-ийн зардал 53,882.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 14,484.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс Батлагдсан төсвийн гүйцэтгэл, түүний хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 1, тухай бүр мэдээлэх цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 33,977.1 мянган төгрөгийн үнийн дүнтэй 1, тухай бүр мэдээлэх Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн 1, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн 1, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн 37,215.8 мянган төгрөгийн дүнтэй 1, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, ...төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 1, нийт 71,192.9 мянган төгрөгийн 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага тул дээрх тогтоолд хамаарахгүй болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 21,132.5 мянган төгрөгийн шатах тослох материал харьцуулалтын аргаар худалдан авах тендерийг сумын ЗДТГ зохион байгуулж, НИК ХХК-тай гэрээг байгуулжээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалтай дүгнэлт авсан, нийт 30,969.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2,038.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 17,833.9 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 11,096.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх 4 заалт бүхий зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн хэрэгжилтийг 2021.12.10-ний 112 тоот албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 310,718.0 мянган төгрөгийн авлага, 92,964.4 мянган төгрөгийн өглөг үүссэнээс ажиллагсадтай холбогдсон 11,034.1 мянга, эмийн 17,358.8 мянга, бусад зардлын тооцооны 63,906.4 мянган төгрөгийн өглөг тус тус үүссэн байна. Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж авсан ба байгууллагын удирдлагаас тайлбар тодруулга албан бичгээр авсан. Дараагийн

аудитаар өглөг авлагын тооцоог барагдуулж ажилласан эсэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,034.9 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрч, санхүүгийн тайланд 8,527.6 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 3,507.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгөв.

4.1. Залруулсан алдаа .

4.1.1 Горим сорил гүйцэтгэх явцад дараах алдаа илрэв. Үүнд:

- 2021 оны 9,10 дугаар сарын халаалтын зардал 4,361.4 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардал руу хаасан

- Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр худалдан авсан 1,807.6 мянган төгрөгийн эм, ороох боох материалыг бусад хангамжийн материал дээр нягтлан бодогч давхардуулж орлого авсан

- Ажиллагсад олгосон урьдчилгаа тооцооны авлагыг 430.2 мянган төгрөгөөр илүү тусгасан.

- Гарт олгох цалингийн өглөгийг үүсгэхдээ өглөгийн дүнгээс авлагыг хассан зөрүүгээр тооцож 1,928.3 мянган төгрөгөөр дутуу тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." гэснийг үндэслэн санхүүгийн тайланд залруулав.

4.2. Албан шаардлага

4.2.1. 2021 оны 12 дугаар сард Нийгмийн даатгалын хэлтэст 1 ажилтны цалингийн санг 195.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст дутуу мэдээлсэн ажилчдын 195.4 мянган төгрөгийн цалинг залруулж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

4.2.2. Баянхонгор аймаг дахь Сум дундын шүүхийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 03 дугаар сарын 09-ний 131/ШШ2021/00171 тоот захирамжаар нягтлан бодогчоор ажиллаж байсан Т.Нарангаравын Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 54 дугаар бүхий тушаалаар ажлаас халагдаад ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн олговорт 3,311.9 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны

Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ. гэснийг үндэслэн Эрүүл мэндийн төвийн даргад албан шаардлага өгөх

4.3. Зөвлөмж

4.3.1.Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллээс нийт 71,192.9 мянган төгрөгийн 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт, 6.3.6. хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл; 6.3.7.хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

4.3.2.Тайлант оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх тооллогын комиссын бүрэлдэхүүнийг байгууллагын даргын 2021 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн 82 тоот тушаалаар байгуулсан ба комиссын бүрэлдэхүүнд нягтлан бодогч, нярав нарыг оруулсан байна

Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна гэснийг зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Цаашид тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилохдоо дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төв	8	12,034.9	4	8,527.6	0	0,00	2	3,507.3	2	0,00

_____оОо_____



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 35/А014425182

Номгон

БНА-2022/56/НА-СТА-7418

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодогч нь 2021 оны 12 дугаар сард Нийгмийн даатгалын хэлтэст нэг ажилтны цалингийн санг 195.450 төгрөгөөр дутуу мэдээлсэн.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн 195,450 /Нэг зуун ерэн таван мянга дөрвөн зуун тавин / төгрөгийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн дарга Г.Сүхбаатар, нягтлан бодогч О.Бямбасүрэн нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 37/А014425182

Номгон

БНА-2022/56/НА-СТА-7Ш5

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Эрүүл мэндийн төвийн дарга Г.Сүхбаатар нягтлан бодогч Т.Нарангаравыг 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 54 дугаар тушаалаар ажлаас чөлөөлжээ. Баянхонгор аймаг дахь Сум дундын Шүүхийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 03 дугаар сарын 09-ний 131/ШШ2021/00171 дугаартай захирамжийг үндэслэн нягтлан бодогчоор ажиллаж байсан Т.Нарангаравт ажлаас халагдаад ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн олговорт 3,311,900 төгрөгийг 2021 онд цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ гэснийг зөрчсөн байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хууль, тогтоомж зөрчиж төсвөөс олгосон цалингийн 3,311,900 /Гурван сая гурван зуун арван нэгэн мянга есөн зуун / төгрөгийг дарга Г.Сүхбаатараар төлүүлж зөрчлийг


арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн дарга Г.Сүхбаатар, нягтлан бодогч О.Бямбасүрэн нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЭНЯМ

“ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТОР  Д.ЦЭЦЭГМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно